

Ион ба хийг таних сэдвийн бататгал дасгал

1. Хлорид, бромид, иодид ионыг ямар бодисоор таньж болох вэ?

A. AgNO_3 B. BaCl_2 C. H_2SO_4 D. NaOH

2. Өнгөгүй уусмал дөлний өнгийг шар өнгөөр будаж, хүчилтэй харилцан үйлчлэхдээ хий ялгаруулдаг, фенолфталеин дусаахад ягаан өнгөтэй болдог бол энэ нь аль бодисын уусмал вэ?


A. CaSO_4 B. Na_2CO_3 C. K_2CO_3 D. MgSO_4

3. Үелэх хүснэгтийн IA, IIA бүлгийн зарим металлууд дөлний өнгийг содон өнгөөр буддаг. Туршилтын үр дүнг тохируулна уу.

Элементийн нэр		Металлын ионы дөлний өнгө	
1	Лити	А	шар
2	Натри	Б	улаан
3	Кали	В	ногоон
4	Бари	Г	хөх ягаан

4. Нөхнө үү.

Сурагч агаараас хүнд хийг гарган авч, хатаахаар дараах багажийг угсарчээ.



а) Зурагт өгсөн хоосон зайд харгалзах багаж, хэрэгслийг нэрлэнэ үү. 3 оноо

б) Сурагч багажаа угсрахдаа гаргасан алдааг олж тайлбарлана уу. 2 оноо

.....
 в) Урвалаас ялгарч байгаа хийг концентрацитай хүхрийн хүчлийн уусмал дундуур нэвтрүүлж байгаа шалтгааныг тайлбарлана уу. 1 оноо